

ҮНЭЛЭМЖИЙН ОНОЛ: ДОМОГ ЗҮЙН ХҮН СУДЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Хулуд Жамьянгийн Отгонбаяр 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2024-03-27

Засварласан - Revised:
2024-04-17

Хэвлэгдсэн - Published:
2024-05-25

otgonbayar@msue.edu.mn

ORCID: [0009-0006-4816-0216](https://orcid.org/0009-0006-4816-0216)



© 2024, Author(s)

Хураангуй: Хүн хэмээх бодгаль оршихуй нэг удаа л хэлд орж сэтгэлгээ нь өрнөн дэвждэгтэй зүйрлэвээс хүн төрөлхтөн хэмээх даяар оршихуй хэлд орсон тийм сэтгэлгээ нь домог зүй билээ. Хүний сэтгэлгээний урагш давших хөдөлгөөн хэдий чинээ гүнзгийрч улам бүр рационал шинж төрхийг олно, төдий чинээ уг язгуур, иррационал сан хөмрөгтөө буцан хандаж хүч тамираа сэлбэх ажгуу. Үүнийг даяаршлын өнөөгийн нөхцөлд үндэстэн, угсаатнууд соёлын дархлаагаа бэхжүүлэхээр эрэл хайгуул хийхдээ өөрийн түүх, уламжлал, өв соёл, сэтгэлгээний онцлог, менталитет тийш шаргуу хандаж буй үйл явцаас харж болох юм. Энэ эрэл хайгуул тэдний домог зүйд тулж очих нь жам. Домог зүй нь тэдний түүхэн сэтгэл зүйн дэлгээстэй ном юм.

Түлхүүр үг: Монголын Цагаан Сар, түүний домог зүйн утга, “Монголын Энх Төр” (“Pax Mongolica”), монголчуудын Тэнгэр үзэл, эрхэмнэл бэлгэдэл, ритуал зан үйл, үндэсний өөрийн ухамсар.

Өмнөтгөл болгон тэмдэглэхэд, гарчигт өгүүлсэн сэдвийн агуулга нь Философийн үүслийн эх сурвалж, онтологи сургаал, хүн судлал, түүхэн сэтгэл судлал, түүхийн философи, боловсрол сургалт, сургуулийн өмнөх боловсролтой холбогдох юм.

Аливаа улс үндэстний нэгэн адил монголчууд бид уламжлал, өв соёл, заншил ёс, үнэлэмж, үнэт зүйлсийн ширгэшгүй ундарга бүхий итгэл оюуны тогтолцоотой билээ. Манай ард түмэн бэлгэдэл эрхэмнэлийн гүн бат язгуур үндэстэй. Хүн төрөлхтний түүхийг Тэнгэр үзэл, Тэнгэрийн зарлигийн дор дэлхийшүүлэн бүтээж, нэр төрөө мөнхжүүлсэн тод ул мөртэй, түүх туурвиж Даяар амгалангийн үзэл, дэг ёс, үнэлэмж тогтоосон өвөг дээдсийн хойчис нь бид юм. Үүнийг дурдах хэмээвээс, золбоо хийморьтой, сайхан монгол хүнийг би сэтгэл оюундаа багтаан тэрлэж, бахархаж байхыг хүсдэгийн учир тэр бүлгээ.

“Муухай монгол хүн”, “олиггүй монгол хүн” гэсэн хэл яриатай бишгүй дээ таарч явдаг л даа. Гэхдээ л уруудаж доройтож, бусдын эрхшээлд орон улаан, цагаан хэрэмний цаанаас хамаарч байсныг бус, сэргэж санаж, бүтээж цогцлоож ид хавтай байсан цаг үеэрээ баримжаалан үлгэр авч манай үндэстэн өөдөлж дэвжинэ гэдэгт эргэлздэггүй юм. Ирж буй цагийг харааж биш, ерөөж байгуулна гэдэгт би итгэдэг. Өсөн дэрвэж буй залуу үеэ үгүйсгэж бус, өргөн тэтгэж эрийн цээнд хүргэнэ, тэгж улс орноороо дэвшин хөгжинэ гэдэгт итгэдэг. Бидэнд эрхэмлэх дээдлэх ёс бий. Бидэнд бас цээрлэх ёсон бий.

Монгол түмэн бэлгэдэл эрхэмнэлийн тогтолцоогоо улам бүр утгажуулан өнгөлж, үндэсний өөрийн ухамсраа сэргээж, соёлын дархлаагаа ямагт бэхжүүлж бататгаж байдаг төр ёс, ураг төрөл, ахан дүүсийн барилдлага, ажил амьдрал, зан заншил, үзэл санааны гол цогц ёслол-үнэлэмжийн нэг нь *Монголын Цагаан Сарын баяр* юм. Цагаан Сарын утга бэлгэдлийн уг язгуурыг мөшгиж,

герменевтик тайлал хийж, үнэлэмжийн онолын байр сууринаас хандвал эл эрэл хайгуул өнө эртний үе рүү, домгийн цаг руу хүрч очих нь гарцаагүй билээ.

Харин Цагаан Сар, түүний утга бэлгэдлийн талаарх өнөөгийн тайлбар бүтээлүүдийн агуулга нь их төлөв дундад эртний үеийн түүхэн сурвалжаас эх аван орчин үежилт, манай саяхны үнэлэмжийн тогтолцооны өөрчлөлт шинэчлэлийг тусгасан байдаг. Энэ нь ч зүй юм. Түүхэн мэдээ сурвалжийг харахад, Цагаан Сарыг эхлээд бөөгийн ёс, буддын шашны ритуал зан үйл, уламжлалаар тэмдэглэж байжээ. Тэмдэглэдэг цаг улирал нь өөрчлөгдсөөр ирж. Утга агуулга нь төр, шашны ёстой гүнзгий холбогдохын сацуу удам судар, ураг барилдлага гээд иргэний өнгө аясаар баяжиж улам бүр тодорч байна. Дашрамд тэмдэглэхэд, бид илбэ дом ба домгийн залгамж чанар хийгээд нэгдмэл байдлыг нь хэтийдүүлэн домог зүйн сэтгэлгээг бөөгийн ёс, ритуал зан үйлийн сүүдэрт орхиж ирсэн гэмтэй.

Цагаан Сар, бас, түүхийн сорилт бэрхшээлтэй тулгарч, өв соёлд маань халдсан гаднын террор, түүнийг иш мухаргүй дагагч увайгүй удирдлага нарын харгайгаар тэмдэглэх хүрээ нь явцуурч, хориглогдох дээрээ тулж, нэг ёсондоо, хэлмэгдэж ч байсан удаатай. Энэ бол түүх, энэ бол бидний авах ёстой сургамж. Цагаан Сар бол манай үндэстний соёлын дархлаа, өв их эрдэнэ, монгол хүний итгэл найдвар, өнө мөнх оршихуйн бэлгэдэл билээ.

Цагаан Сар өнөө цагийн бидний үнэлэмж эрхэмнэлийн цогцлол хэдий ч, түүнээс өнө эртний өвөг ихэс, нэн ялангуяа домог зүйн үзэл, сэтгэлгээнд суурилсан хүчирхэг дээдсийн уриа дуудлага сонсогддог юм. Хараач! Сар шинэдээ сайхан *шинэлж* байна уу, Сар шинэдээ сайхан *шинэлэв* үү хэмээн мэндчилэн золгож байгаа биз? Амар мэндийг эрсэн энэхүү мэндчилгээний *домог зүйн утга* нь юу байсан юм бол?

Онолын мэдлэгийн ангиллын талаар олон янзын үзэл, хандлага байдаг. Тэдгээрийн дотор мэдлэгийн бүтээгдсэн арга замыг онцолдог хандлага бий. Ийм хандлагыг баримтлагч зарим судлаач онолын мэдлэгийг бүлэглэхдээ *шинжлэх ухаан, үнэлэмжийн онол, эзотерик мэдлэг* хэмээн төрөлжүүлсэн байдаг¹. Тэгэхдээ энэ нь онолын мэдлэгийг дээр ба дор, чухал ба чухал бус хэмээн ялгаварлах гэсэн санаархал огт биш. Харин өнөө цагийн мэдлэг судлал, сургалт судалгаанд *үнэлэмж*, түүний онолын байр суурийг тодлох гэсэн хэрэг юм.

Философи бол онолын мэдлэгийн тогтолцоо билээ. Гэхдээ шинжлэх ухааны онол бус, үнэлэмжийн онол мөн хэмээх байр суурийг баримталж байна. Дашрамд тэмдэглэхэд, Үнэлэмжийн онол хэмээх ойлголт өргөн хүрээг хамаардаг. Үүнээс үнэлэмжийн тухай философи онолыг аксиологи (axios – үнэ цэнтэй, logos – сургаал гэсэн утга бүхий грек үгнээс гаралтай нэр) гэдэг.

Шинжлэх ухааныг мэдлэгийн дээд төрөл гэж үзэхийн сацуу өөрийгөө ч шинжлэх ухаан хэмээн манайд уламжлан тунхаглаж байсан марксист философид ер нь үнэлэмжийн мэдлэгийг субъектив шинжтэй, эерэг бус утгатай хэмээн арын эгнээнд авч үзэж байлаа. Хэдий тийм боловч энэ философийн хүрээнд ч олон судлаач, философич үнэлэмжийн асуудлыг онолын төвшинд боловсруулж байснаас орос-зөвлөлт, зөвлөлт-оросын философич А.Ф.Лосев (Знак. Символ. Миф. Труды по языкознанию. — М., 1982), В.П.Тугаринов (Теория ценностей в марксизме. — Л., 1968. Философия сознания. — М.: Мысль, 1971. - 199 с.), Б.Т.Григорьян (Философия и ценностные формы сознания (Критический анализ буржуазных концепций природы философии. Ответственный редактор Б.Т.Григорьян. — М.: Наука, 1978), М.С.Каган (Человеческая деятельность. Опыт системного анализа). М., 1974) нарын зэрэг олон судлаачийн үзэл онолтой танилцаж, бүтээл туурвилыг нь уншиж үнэлэмжийн талаар суурь ойлголттой болж байлаа.

Тийм онол номлол ёсоор, философи нь *шинжлэх ухаанч онолын ба үнэлэмж-ертөнцийг үзэхүйн* бүрдэл элементүүдийг өөртөө амин нэгдэл байдлаар нэгтгэдэг гэж үзэж байв. Өөрөөр хэлбэл, хүнээс ертөнцтэй харилцах практик, оюун санааны харилцааны зэрэгцээ хэрэгждэг *практик-оюуны*² хэмээх харилцааг онцолж байв. Энэ томъёолол К.Марксаас эх сурвалжтай, тухайлбал, тэрбээр юмсын үнэ цэн, үнэт чанарыг таваарт *шингэсэн* хийвэр хөдөлмөр буюу өртгийн онолоор тайлбарладаг. Түүний “Эдийн засаг-философийн гар бичмэл”-д нь “мэдрэмжийн чадамж” хэмээн илэрхийлэгдэж байсан сайхи ойлголтын утга хожмоо “Эдийн засгийн гар бичмэлүүд”-д нь *уран сайхны, шашны, ёс зүйн харилцаа* руу өргөжсөн тал бий.

Өнөө бидний номлож буй философийн практикт *үнэлэмж гэдэг бол субъектын зүгээс юмс үзэгдэлд шингээж оноож буй утга холбогдол юм*. Ингэж авч үзэхэд, орчлон хорвоог овгийнхоо загвараар, синкретик оюунаараа төсөөлсөн эртний хүмүүс байгаль орчлонг домог зүйгээрээ оосорлон утгажуулж, нэг ёсондоо, *үнэлэмжжүүлж*, түүнийг зэрлэг дүр төрхөөс нь салган “хүмүүнжүүлсэн” болой.

Домог зүй нь овгийн нийгмийн ураг барилдлага, аж төрөхүйн хэм хэмжээ, дүрэм горим, ёс суртахууны цөм үнэлэмж, үнэлэмжийн язгуур сан хөмрөг юм. Эцсийн эцэст, утга соёлын аливаа хэлбэр эндээс л эх авчээ. Миф домог, домог зүй нь овгийн хүмүүсийн хувьд хамгаас бодит ертөнц юм. Өөрөөр хэлбэл, өнөөгийн манай нийгэмд зах зээлийн харилцаа бодит байдал байгаагийн адил домог зүй нь тэдний хувьд тийм бодит оршихуй байжээ. Энэ бол Хүний ахуй, “эхлэлийн эхлэл”³ (Мирча Элиаде) юм. Үүний учир хүн төрөлхтөн цаг үргэлжид Эхлэл ахуй руугаа буцаж байдаг. Тийм болохоор, түүх бол “мөнхийн буцалт”, үе үеийн үнэлэмж, үнэт зүйлсээ дахин хянан үзэж, шинэчилж байх тухай Фридрих Ницше зүгээр ч нэг бичсэнгүй ээ.

Домог зүй бол домгийн цагийн хүний домгийн сэтгэлгээний үр дүн болох домгуудын нийлбэр тогтолцоо юм. Домог судлалаас эхсүүлээд олон салбар ухаан (шашин судлал, соёл судлал, хэл шинжлэл, хүн судлал, утга зохиол судлал гэх мэт) домог зүйг өөр өөрсдийн арга хандлагаар судалдаг. Домгийг судалдаг антропологи онолууд бий. Энэ чиглэлийг Э.Тайлор, Ж.Фрэзер, Б.Малиновски, Э.Дюркгейм, Л.Леви-Брюль, Э.Кассирер, К.Леви-Стросс гээд шашин, соёл, угсаатан судлалын мундагчууд магнайлдаг.

Гэхдээ домог зүйн хүн судлал гэсэн бие даасан салбар ухааныг төлөвшсөн хэмээн үзэхэд хараахан эрт юм. Харин судлаачид хүн судлал (антропологи), шашин судлалын дотоод бүрэлдхүүнд домог зүйн зарим аспектыг авч үздэг. Тухайлбал, соёлын хүн судлалд хүн, нийгмийн үүсэл гарлын тухай *антропологи домгууд*, мөн соёлын үнэт зүйлсийн гарал үүсэл, тэдгээрийг олсон, хэрэглэх болсон *соёлт баатруудын* үйл ажлын тухай домог зүйг, өөрөөр хэлбэл, домог зүйн сэтгэлгээнд хүн хэрхэн төсөөлөгдсөн бэ (олон гартай, олон нүүртэй, олон нүдтэй, эсвэл ганц нүдтэй, олон толгойтой гэх мэт) гэдэг асуудлыг онцолсон байдаг.

Энэ хандлагыг явцуу хэмээн үзэж болох юм. Гэхдээ энэ нь тухай судлаачдыг өөлөх гоочлох гэсэн хэрэг огтоос биш. Харин *үнэлэмжийн онол, психологийн философийн* байр сууринаас асуудалд хандах гэсэн оролдлого санаа юм.

Энэ санаа бол, *нэгдүгээрт*, домог зүйн сэтгэлгээнд *антропоморфизмын зарчим* түгээмэл үйлчилгээтэй тул домог зүйн хүн судлалын судлагдхууны хүрээг өргөтгөх шаардлагатай гэх явдал юм. Могой, матар толгойтой хүн, арслан, адуу хүн цээжтэйгээр төсөөлөгдөж буй нь тэдгээр амьтад “хүлэг”, хүн төрхтэй гэхийн сацуу хүнийг бас тийм “амьтанлаг” гэсэн төсөөлөл бололтой байдаг.

Хоёрдугаарт, тухайлсан домог дахь хүний дүр төрхийг хайж, тэр талаарх өгүүлэмжийг онцолж тайлбарлахын сацуу ер нь домгийг бүтээгчид, хэрэглэгчдийн, товчхондоо, домгийн цаг үеийн хүний сэтгэлийн төлөв байдал, оюуны царааг домог зүй хэмээх бүтээлээр нь авч үзэж болох юм. Жишээлбэл, Сизифийн тухай домгийн далд өгүүлэмжээс *хүний хувь заяа, амьдралын утга учрын тухайд тэр цагийн хүмүүс хэрхэн сэтгэж вэ* гэдгийг “уншиж” болдог бол Эрхий мэргэн хэмээх домог үлгэрээс *орчлон ертөнц бүтээгдсэн ерөнхий зарчмын* гол санаа нь дээд төрлөөс доод төрөл тийш чиглэх хандлагатай байж хэмээн уншиж болохоор юм.

Гуравдугаарт, домог нь тухайн цагтаа байнгын хэрэглээтэй, энэ хэрэглээ нь зөвхөн ярих, хурайлах, зүхэх занahaар хязгаарлагддаггүй, домгийн өгүүлэмж-агуулгыг “хийдэг, бүтээдэг” бүлгээ. Тодруулбал, домог зүй нь уялдаа холбоо бүхий домгуудын үргэлж, цул, бүхэл бүтэн нэгдмэл

тогтолцоо байсан бөгөөд домог тус бүр нь *дагалдах ритуал зан үйлтэй* байсан аж. Жишээ нь, тэнгэрээс бороо хур гуйж ерөөл хүслээр хандахын сацуу бороог “хийдэг” байжээ. Энэ нь салхи, үүл, тэнгэрийн нүргэлэх дуу, гялбах цахилгаан, бороо хурыг дүрслэн харуулсан тайзчилсан ритуал зан үйл хийх явдал юм. “Бороо орохгүй бол ургамал гандан хагдарч, хүмүүс зовж шаналан, үхэх болно. Ийм учраас овгийн нийгмүүдэд бороо хурыг урин дуудагч этгээд бол тун чухал хүн болж байв... Тэрбээр хэрэв хур бороо урин дуудахыг хүсэж буй бол ус шүрших, эсвэл, үүлийг даган дууриах байдлаар үйлдэл гүйцэтгэдэг, харин тэрбээр бороо хурыг зогсоож, хэтэрхий ихэдсэн чийг усыг хатааж ууршуулахын тулд галын нөхцөл боломжийг ашигладаг”⁴. Тэгэхээр, домгийг мэднэ, ойлгоно гэдэг бол түүний өгүүлэмжийг төдийгүй, бүрэлдэхүүний зан үйл, ертөнцийг залагч синкретик сэтгэлгээний мөн чанарыг ойлгох явдал юм.

Дөрөвдүгээрт, домог зүйн сэтгэлгээ ид зонхилж байх үеийн хүмүүст бүх зүйл эргэлзээгүй ойлгомжтой тул домогт танин мэдэхүйн чиг үүрэг, функци байсан гэхэд эргэлзээтэй санагддаг юм. Харин тэдний амьдралд нь үнэлэмж, сүсэг итгэл давамгайлсан харилцаа зонхилж байсан билээ. Тэд хүмүүс юуг мэдэх ёстой вэ гэвэл, тухайн юмсын гарал үүслийн тухай, бүр Орчлонгийн гарал үүслийн тухай мэдэж байх учиртай аж. Энэ тухай мэдлэг нь гагцхүү домог, домгийн өгүүлэмжид л байдаг. Энэ бол “юуны” тухай төдийгүй, юуг яаж хийх тухай барил тавил, хэвшил юм. Энэ бол танин мэдэхүйд үндэслэсэн биш, харин үнэлэмжид суурилсан мэдлэг дадал билээ. Харин домгийн сэтгэлгээний энэхүү зонхилон давамгайллын үе нь өмнөх илбэ домын сэтгэлгээний үетэй харьцуулахад харьцангуй түргэн зуурынх билээ. Яагаад гэвэл, Франц Боасын тэмдэглэсэнчлэн, “Хэлтэрхий бүрээсээ шинэ ертөнц төрүүлэхийн учир миф домгийн ертөнц нь үүссэн даруйдаа задарч бутрах нигууртай”⁵ (*Дам эилэв – Ж.О*) хэмээн хэлж болох билээ. Өөрөөр хэлбэл, домгийн сэтгэлгээний дотоодод эргэлзээ, зөрөө үүсч, шинэ чулууны хувьсгал гүнзгийрэхийн хирээр ураг барилдлагын зэрэг ахуйн харилцаатай харшилдаж, төрөлжин нарийсч, домгийн тогтолцооны үргэлж цул байдлын дотоод таталцал суларсан байх талтай.

Тавдугаарт, домог зүйн хүн судлалыг зөвхөн антропологи домогуудаар хязгаарлах явдлыг өрөөсгөл хэмээн үзэж болох юм. Яагаад гэвэл, орчлонгийн үүслийн тухай космогони домог ч *овгийн хүний ахуй* юм. Домог зүйн гарамгай судлаач Мирча Элиаде “Орчлонгийн үүслийн домог, өвчин ба эмийн ургамлын гарал үүслийн домог, бас энэ өвчнийг анагаах шидлэг зан үйлийн хооронд гайхамшигтай холбоо байдаг”⁶ гэжээ. Өөрөөр хэлбэл, Орчлонгийн үүсэлтэй холбож эмчлэхгүй бол өвчин эдгэхгүй гэсэн үг юм. Овгийн үеийн хүмүүс юмсын үүсэл гарлыг үйлдэл харилцаагаараа байнга давтан сэргээн санаж, загварчилж, өөрсдийн хүсэл зоригоо юмст хэрхэн тулган хүлээлгэхээ ямагт мэдэж байх тул Орчлон ертөнцийг сэргээн, шинээр бүтээж, хүч тамирыг нь идэр төгс байлгадаг буюу. Ийм идэр төгс байлгах гэсэн заншил ёс бол илбэ домын сэтгэлгээнээс домгийн ертөнц рүү уламжлан ирсэн, нэг талаас, нар, бороо хурыг тэгш байлгах, нөгөө талаас, ургамал жимс, хоол хүнсийг элбэг дэлбэг, хүн зоньг үржил өсөлттэй байлгах гэсэн домог-ритуал үйл юм.

Зөвхөн домгийн үеийн хүмүүс, овгууд төдийгүй, хожуу үеийн зарим ард түмэн хаан ширээнд хааныг залах үйлээрээ орчлонгийн үүслийг бэлгэдэл байдлаар давтдаг байсан тухай судлаачид тэмдэглэсэн нь цөөнгүй байдаг. Тухайлбал, “Энэтхэгийн хаан *ражасуйн* хаан ширээнд залрах үйлийг ариусган ёслох нь Орчлонг сэргээн бүтээхийг шаарддаг... Хаан гараа өргөж байдаг, энэ нь *ертөнцийн* тэнхлэгийг өргөх үйлийг бэлгэддэг. Хаан нь адислах зан үйлийн үеэр хаан ширээн дээр гараа өргөн зогсч байдаг, өөрөөр хэлбэл, тэрбээр Газар Дэлхийн хүйг (хаан ширээ нь ертөнцийн Төв байж таардаг) дайран өнгөрч, Тэнгэрт хүрч буй сансар орчлонгийн тэнхлэг болж байдаг. Ус цацан үсэргэх үйл нь Газар Дэлхийг үртэй болгохын тулд тэнгэрээс ертөнцийн гол тэнхлэгийг (тодруулбал, хааныг) даган доош бууж буй устай адилсдаг аж...

Түүхийн цаг үед ражасуйг хоёроос илүүгүй удаа давтан үзүүлэх сургууль (зан үйл) хийцгээжээ, эхний удаад хааныг адислахын тулд, хоёр дахь удаад хэмжээгүй, дээд эрх мэдэл

олгохын тулд хийжээ. Харин түүхийн өмнөх цаг үед энэхүү ёслол үйлийг жил бүр зохион байгуулж, Орчлонг дахин төрүүлэхийн тулд үүнийг хийж байсан нь илэрхий юм”⁷ хэмээн онцолжээ.

Эндээс харахад, хааны энэхүү “тангараг өргөх ёслол” нь Орчлонг шинэчлэн бүтээх үйлийн бэлгэдэл утга ажээ. Ингэж үзвэл хаан болоод тэр овог хүмүүсийн “үндсэн хууль” нь Орчлонгийн үүслийн тухай тэр угсаатан түмний космогони домог байжээ. Харин бусад үргэлжлэл домог нь тэрхүү “үндсэн хуулийн” “салбар хуулиуд” болой. Ийн хандваас, хэдийвээр хүн төрөлхтний миф домгийн эталон, дээд жишиг мөн эсэх тухай маргаан байдаг ч, ураг барилдлага хийгээд ажил үүргийн хуваариар шүтэлцсэн Зевс тэргүүтэй Олимпын Тэнгэр-Бурхад, тэдэнд хандсан элдэв ёслол үйл цөмийг Хүй Орчлонг шинэчлэх, тогтоон барих агуулга зорилго бүхий хэмээн үзэж болох билээ.

Хаан орчлонг шинэчлэн бүтээж буй үйлтэй холбогдуулан бас нэг зүйлийг тэмдэглэх нь зүйтэй юм. “Энэ шинэчлэл үндсэндээ чухам л Шинэ Оноор, улирлын шинэ мөчлөг эхэлснээр хэрэгждэг. Гэхдээ энэ үед ритуал үйлээр хэрэгжиж буй *шинэчлэл* нь мөн чанартаа ертөнцийг бүтээх үйлийн давталт байдаг. Ийн бүтээхүй нь шинэ жил бүрээр давтагдана. Чухам ийм учраас, космогони домгууд ертөнц хэрхэн бүтээгдэн байсан хийгээд хожим хойшид нь юу болж өнгөрснийг хүмүүст сануулах бүлгээ”⁸.

Тэгэхлээр, домог зүй судлаач эрдэмтний үгээр илэрхийлэхэд, сайхи шинэчлэл нь “өнгөрснийг сануулах” *үзүүлэх сургууль* бөгөөд цаг улирлын мөчлөгтэй уялдан нийгэм-эдийн засгийн бүтцийн ялгаа болон соёлын орчил нөхцөлийн янз бүрийн байдлаас үл хамааран балар эртний ард түмнүүд ертөнцийг жил бүр шинэчлэх ёстой, энэхүү шинэчлэл нэг загвараар, космогони домгийн үүрэг гүйцэтгэж байдаг гарал үүслийн тухай домгийн загвараар хийгддэг ажээ.

Эндээс харахад, нэгэнт домгийн үеийн хүний сэтгэл зүй, сэтгэлгээн дэх төсөөлөл мөн болохын хувьд Орчлонгийн үүслийн тухай космогони домог ч хүн судлал руу хамааралтай байж болохоор байна. Иймд, Домог судлал ч өргөн утгаараа Хүн судлал байх юм.

Дээр өгүүлсэн бүхнийг үндэслэн дүгнэлт болгоход, домог зүйн утгаар авч үзвэл, Монголын Цагаан Сар бол Орчлон хорвоог хүн зонтой нь *шинэчлэн бүтээж* байсан домгийн цагаас язгуур сурвалжтай агаад олон хувирал хэлбэрийг дамжин, манай монгол түмний цаг цагийн үнэлэмж эрхэмнэлийг шингээсээр эдүгээ утга бэлгэдэл нь улам бүр төгөлдөршиж, Сарны тооллын шинэ жил солигдох мөчлөгийг тохиол учрал болгон даяар бүгдээрээ цагаалж шинэлж байгаа Сар Шинийн баяр юм. Ийм учраас “Сар Шинэдээ сайхан шинэлэв үү?” гэх *шинэлгээ золголтын* мэндчилгээг хууч эртний *Орчлонг шинэчлэн бүтээхүйн* шилжирсэн утгын илэрхийлэл хэмээн үзэж байна.

Дэлхийн түүхээр хэмжээлэн авч үзвэл монголчууд Даянд Энх Төрийг⁹ тогтоон барьж, хэдэн зууны туршид Их амар амгаланг хамгаалсан шинэчлэгч, хүний орчлонг *жинхэнэ утгаар нь бүтээн туурвисан* ард түмэн билээ. Энэ тухайд нэрт монголч эрдэмтэн В.Котвич Их Монгол Улсын төр тийнхүү даян дэлхийд амар амгаланг тогтоож, “Монголын их амар амгалан”, “Монголын энх төр” (“*Pax Mongolica*”)–ийг 13 дугаар зуунд бүтээсэн хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг. Хүн төрөлхтөн тэр цагт тийнхүү даяншиж, Дэлхийн түүх мэндэлсэн хэмээн цараатай эрдэмтэд, судлаачид үзсэн нь санамсаргүй хэрэг биш ээ.

Манай өвөг дээдэс Тэнгэрийн зарлигийг түшиж, Мөнх Тэнгэрийн амар амгаланг газарт тунхагласан их үйл хэргийн үндэс болбоос тэдний домогт хөллөсөн Тэнгэр үзэл нь байлаа. Тэнгэр үзлийнх нь хураангуй бэлгэдэл болбоос Есөн хөлт цагаан туг хэмээх домог зүйн угшилт байгууламж байжээ.

Axiology (Theory of value): certain issues on mythological anthropology

Khulud Jamyan. Otgonbayar

Department of Social Science, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

Abstract: The man, which is individual existence learns to speak so his mentality upgrades, mythology is, analogizing to mankind, which is throughout existence learnt to speak.

As much as man's mentality heads to up and deepening to rational features, that much overhauls by heading back into irrational treasure and his originality.

While ethnics and nations prospecting to strengthen cultural defence in today's globalizational period, we can observe that, they have urgently heading into own tradition, thinking feature and mentality.

The prospecting bringing to face to their mythology is necessity. Mythology is opened book of historical psychology.

Key words: Mongol's Lunar new year, its meaning of mythology, "Peaceful state of Mongolia" ("Pax Mongolica"), Mongolian shamanism and tenggerism, symbolism and value judge, ritual custom, national own consciousness .

Ном зүй

Гомбосүрэн Ц, Дагзмаа Б. (2013) Нийгмийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн ухааны сургалтын тулгамдсан асуудал. – Философи, эрх зүйн боловсрол.эрдэм шинжилгээний бичиг. УБ., "Битпресс" №6 х.77-91

Григорьян Б.Т (1978) Философия как способ практичекки-духовного освоения мира. – В кн: Философия и ценностные формы сознания. М., "Наука". С.3-22.

Мирча Элиада. (2020) Домог зүйн сэтгэлгээ (Орч. Хулуд Ж.Отгонбаяр) УБ. "Жиком" х. 41-64.

Фрэзер Ж.Ж. (2024) Домог зүйн хүн судлал (Илбэ домын сэтгэлгээний мөн чанар). УБ., "Жиком" х.127-181.

Леви-Строс К.(2013) Бүтцийн антропологи. УБ., "Монсудар" х.189

Мирча Элиада (2020) Домог зүйн сэтгэлгээ. УБ., "Жиком" х.45-50

Мирча Элиада (2020) Домог зүйн сэтгэлгээ. УБ., "Жиком" х.64-82

Мирча Элиада (2020) Домог зүйн сэтгэлгээ. УБ., "Жиком" х.64-72

Котвич В. (2020) XIII зууны эхэн үед монголчууд дэлхий нийтийн энх тайвангийн санааг сэдэж үүсгэсэн болох нь. – Хэл зохиол судлал. Боть IX, Дэвтэр. УБ.,